



БҮСЧЛЭЛ БА БҮСИЙН БАЙГУУЛЛАГА: МОНГОЛД ҮЗҮҮЛЭХ ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨ

Илтгэгч: **С. Ганзориг & М. Найдалмаа, оюутан**

Masters of Arts in International Organisation, Dublin City University, Ireland

Өнөөдөр хүн төрөлхтөн хурд нэмэх жамаар өсөн дэвшиж хөгжиж байна. Хүн төрөлхтөний эхлүүлсэн энэхүү хөгжлийн хурд нь цаг хугацаатай уралдан, хувь хүн байтугай улс гүрэнд ч захирагдахын аргагүй болтлоо даяаршиж, аливаа шашин шүтлэг, нас хүйс, баян ядуу, арьс өнгөний ялгаваргүй тэр ч бүү хэл хил хязгааргүй нэгэн засаглалтай даяаршсан дэлхий рүү биднийг хөтлөж явна.

Нэгэн үе Монголын Эзэнт Гүрэн нь дэлхийн харилцаа холбооны хурдыг өөрчилж, худалдаа арилжааны гол үүргийг гүйцэтгэж байсан түүх бий.

Гэтэл өнөөдрийн Монгол улс нь даяарчлалын өнөө цагийн нүүр царай болсон бүсчлэлийн ямар нэг байгууллагад элсээгүй цорын ганц улс болж хөгжлийн хурднаас хоцорч явна.

Дэлхийн бүх улс орнууд газар зүйн байршлаасаа хамааран хэд хэдэн бүсийн байгууллагуудад элссэн байдаг.

Бүсчлэл нь (regionalism) харьцангуй шинэ ойлголт бөгөөд судлаачид 1980 оноос эрчимтэй судлаж эхэлжээ. Үүнийг 2 үндсэн үечлэлтэй гэж үздэг, эхнийх нь дэлхийн II дайны дараах үеэс 1970-аад он хүртэл, дараагийнх нь 1980-аад оноос хойших үе юм. Эхний үечлэл үндсэндээ чөлөөт худалдаа болон бүс нутгийн аюулгүй байдлын шинж чанарыг агуулж байсан бол, харин дараагийнх нь эдийн засгийн интеграцлал болон хөрөнгө хувьчлал дээр илүү түлхүү анхаарал хандуулжээ.

Бүсчлэлийг салбар бүрээр тайлбарлаж болох 17 төрлийн тодорхойлолт байдаг бөгөөд энэ утгаараа одоо хүртэл нэгдсэн нэг тодорхойлолтонд хүрээгүй байна. Joseph Nye үүнийг “улс хоорондын олон талт үйл ажиллагаагаараа уялдсан байгууллага, холбоо, бүлэглэлүүдээс бүрдсэн, газар зүйн байршлаараа холбогдсон тодорхой хэмжээний бүлэг улсууд юм” гэж тодорхойлсон байна (Nye 1968).

Бүсчлэлд хамаарагдах үндсэн хоёр шалтгаан байдаг. Нэг нь тухайн улс тусгаар тогтнол ба аюулгүй байдлаа хамгаалах үүднээс жишээ нь, НАТО, ШХАБ (Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага)-д элсэх, нөгөө нь бүсийн худалдааны байгууллагад элсэх үүднээс эдийн засгаа харилцан ашигтай хөгжүүлэх, жишээ нь EU, ASEAN (Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо), NAFTA (Хойд Америкийн Чөлөөт Худалдааны Бүс), LAFTA (Латин Америкийн Чөлөөт Худалдааны Бүс) гэх мэт.

Ихэнх судлаачид бүсчлэлийг глобалчлалын бас нэгэн үе шат гэж авч үздэг. Глобалчлалыг ямар нэг хүний арьс өнгө, гарал үүсэл, шашин шүтлэг болон нас хүйсээр нь ялгалгүйгээр тэгш эрхтэй, нэгдсэн нэг засаг захиргаатай, эдийн засгийн хувьд бүрэн интеграцлагдсан дэлхий гэж тодорхойлдог ба энэ утгаараа Европийн Холбоо нь энэ бүгдийг өөртөө агуулсан бүсийн байгууллага болоод байна. Судлаачид Европын Холбоог глобалчлалын эхний үе шат болох бүсчлэлийн сонгодог жишээ гэж үздэг.

Одоогийн байдлаар дэлхийд 320 бүсийн байгууллага эдийн засаг, худалдаа, аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Харин Монгол Улс нь дэлхийд ямар нэг худалдааны бүсийн байгууллагад элсээгүй цорын ганц улс юм. Тэгвэл яагаад Монгол одоо болтол ямар нэг бүсийн байгууллагад элсээгүй вэ? Бүсийн байгууллагад элссэнээрээ монгол улсын аюулгүй байдал, эдийн засагт ямар ашигтай вэ?

Монгол улс нь газар зүйн байрлалаараа хоёр том гүрний дунд хавчигдсан, хоёр хөршөөсөө шалтгаалсан хязгаарлагдмал эдийн засагтай улс юм. 1990-ээд оноос хойш Монгол улс хоёр хөрш орныхоо эрх ашгийг хөндөхгүй, хэт нэг талыг барихгүйгээр харилцаж иржээ. Жижиг эдийн засагтай улс том гүрэнтэй эдийн засгийн интеграцлалд ороход тухайн том гүрний улс төр, эдийн засгийн бүрэн хараат болох нөхцөл бүрддэг. Харин бүсчлэл нь бидэнд хоёр хөршийн эдийн засгийн хараат байдлаас ангижирч худалдаа, зах зээлийнхээ хүрээг тэлэх боломж олгож байна.

Бүсчлэл дэх улс хоорондын эдийн засгийн интеграци нь дараах төрөлтэй. Үүнд:

- Хөнгөлөлттэй тарифийн гэрээ. Гэрээ хийсэн орнуудын тодорхой хэсэг бараан дээрх худалдааны тарифийг гуравдагч оронтой хийж буй худалдааны тарифтай харьцуулахад хямд байна.
- Хэсэгчилсэн татварын эвсэл. Дээрх гэрээнд оролцож буй орнууд тодорхой хэсэг бараан дээр гуравдагч оронтой худалдаа хийхдээ нэгдсэн гадаад тарифтай байна.
- Чөлөөт худалдааны бүс. Энэ гэрээ хэлэлцээрт хамрагдсан улсууд хоорондох худалдааны тарифаас бүрэн чөлөөлөгдөж, гуравдагч оронтой хийх худалдааны тариф нь өөр заалттай байна. (LAFTA, NAFTA, SAFTA)
- Нэгдсэн гаалийн татвар. Хамрагдагч улсууд дотоод тарифаа чөлөөлөхөөс гадна гуравдагч оронтой хийх худалдаандаа нэгдсэн гадаад тарифийг баримтална. (EAEC¹, EEA², and MERCOSUR³)
- Нэгдсэн зах зээл. Энэхүү эдийн засгийн интеграци нь нэгдсэн гаалийн татвараас гадна хүн ам, үйлчилгээний чөлөөт шилжилт, бараа таваар, хөрөнгийн чөлөөт эргэлтийг багтаана.
- Эдийн засгийн эвсэл. Улс хоорондын энэхүү эвсэл нь нэгдсэн зах зээлээс гадна татварын, аж үйлдвэрийн, бүсийн, тээврийн болон бусад эдийн засгийн нэгдсэн бодлоготой байна. Мөн мөнгөн тэмдэгтийн нэгдсэн нэгжтэй байх бодлогыг баримтлана. (OECs⁴, EMU⁵)
- Бүрэн эдийн засгийн эвсэл. Энэ нь эдийн засгийг интеграцийн хамгийн сүүлийн шат бөгөөд эдийн засгийн нэгдсэн нэг бодлоготой, түүнийг хариуцсан эдийн засгийн томоохон эрх мэдэл бүхий засгийг газартай байна. (Jovanovic 1998).

Ихэнх судлаачид эдийн засгийн интеграци нь дээрх үе шатлалаар явагддаг гэж үздэг боловч бүсчлэлийн хувьд түүн доторх улс хоорондын харилцаа, эдийн засгийн хөгжлөөс шалтгаалан дээрх төрлүүд нь үл шаталсан байж болно.

Дээр өгүүлсэнчлэн бүсийн байгууллагуудын үүсэл шалтгаан нь янз янз байдаг. Жишээ нь, Европын Холбоо нь анх Европын Нүүрс болон Төмөрлөгийн Нийгэмлэг нэрээр 1957 онд цэвэр эдийн засгийн үүднээс байгуулагдаж байсан бол түүнээс хойш өргөжин тэлсээр одоогийн байдлаар өөрийн гэсэн парламент (European Parliament), нэгдсэн армитай (Military of the European Union) болтлоо хөгжиж эдийн засгийн эвсэл болтлоо интеграцлагджээ. Мөн Шанхайн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг гэхэд бүс нутгийн аюулгүйн байдлыг хамгаалах үүднээс байгуулагдаж байсан бол одоо чөлөөт худалдааны бүс нутаг болох зорилгоор ажиллаж байна. Монгол улсын хувьд дээрх долоон интеграцлалын эхний дөрөв нь ашигтай боловч, Монгол улс шиг газар нутгаар том, ашигт малтмалаар арвин, хүн ам цөөн, эдийн засгийн буурай хөгжилтэй орны хувьд их гүрэнтэй сүүлийн гурав буюу нэгдсэн зах зээл, эдийн засгийн, бүрэн эдийн засгийн эвслээр интеграцчлагдах нь аюултай нөхцөлд хүргэж болох учраас ийм боломж байхгүй юм.

Бүсийн гэдэг утгаараа Ази тивд ASEAN, АПЕС, ШХАБ гэсэн томоохон эдийн засаг, худалдааны үг орхигдсон байгаа билээ. ASEAN нь Зүүн Өмнөд Азийн улсуудын эвсэл учраас манай улс элсэх магадлал бараг байхгүй. АПЕС буюу Ази Номхон далайн эдийн засгийн нийгэмлэг нь бүсийн хамгийн том худалдааны байгууллага юм. Манай улс үүнд элсэхээр хэд хэдэн удаа өргөдөл гаргасан боловч одоо болтол дорвитой хариу өгөгдөөгүй байгаа билээ. Үүний үндсэн шалтгаан нь эдийн засгийн хүрээ хязгаарлагдмал, мөн далайд гарцгүй байгаад оршиж байгаа юм.

Тэгвэл бидэнд элсэх хамгийн боломжтой ямар байгууллага байна вэ?

Газар зүйн байрлалаас шалтгаалан Монгол Улсад элсэх боломжтой байгууллагын нэг бол Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага болоод байна. Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын (ШХАБ) үүссэн зорилго нь Төв ази болон Орос, Хятадын хилийн тогтвортой байдлыг хадгалах үүднээс байгуулагдсан боловч олон улсын хэмжээнд ШХАБ-ыг НАТО-гийн ноёрхолийн сөрөг байгууллага гэж авч үздэг. Өмнө өгүүлсэнчлэн анхны зорилго нь цагийн аясаар хувирч өнөөдөр гишүүн улсууд хоорондоо “Хөнгөлөлттэй тарифийн гэрээ”, “Хэсэгчилсэн татварын эвсэл” хэмжээнд худалдаа хийдэг эдийн засаг, худалдааны зорилготой, цаашид 2015 гэхэд - “Чөлөөт Худалдааны Бүс” болох зорилго тавиж ажиллаж байна.

2004 онд Монгол улс нь ШХАБ-д хамгийн анхны ажиглагч статустай болжээ. Түүнээс хойш Монголыг гишүүн улсаар элсүүлэх санал хэд хэд тавигдаад байгаа ч үүнийг анхны зорилгоор нь авч үзсээр байгаа юм (Баярхүү, 2007). Хэрвээ Монгол улс нь ШХАБ-д гишүүн орноор элсээд Чөлөөт Худалдааны Бүсд хамрагдаж чадах юм бол манай улс нь эдийн засгийн хараат байдлаас гарч хоёр хөршүүдээс гадна Төв азийн улсуудтай эдийн засгийн хувьд бүрэн интерацчлагдах бүрэн бололцоотой болох юмаа.

Монголчууд бид нар Шанхайн гэдэг нэрнээс улбаалаад Хятадын байгууллага тэр тусмаа цэргийн хүчнийх гэж ойлгосны үүднээс ШХАБ-д элсэх бүү хэл хардаж сэрдсэн байдлаар хүлээн авдаг. Гэтэл дэлхий нийтээр интеграцчлагдаж байгаа өнөө үед үндэсний аюулгүйн байдал, жижиг улсын эрх ашиг гэх мэт

¹ Eurasian Economic Community

² European Economic Area

³ Southern Common Market

⁴ Organisation of Eastern Caribbean States. The East Caribbean Dollar is used by Anguilla, Antigua and Barbuda, Dominica, Grenada, Montserrat, Saint Kitts and Nevis, Saint Lucia, and Saint Vincent and the Grenadines.

⁵ Economic and Monetary Union. Euro used by 16 member states in EU.

зүйлээс шалтгаалан Монгол улс ганцаардлын байдлаар өдийг хүрсэн билээ. Нэгэнт Монгол улсын эдийн засгийн 70% нь хоёр хөршөөсөө хамаарсан өнөө цагт бид хойш суулгүй дэлхийн зах зээлийн тавцанд өөрийн гэсэн байр сууриа олохгүй бол эдийн засгийн хараат байдлаасаа хэзээ ч гарахгүй, улам ч гүнзгийрэх болно.

2007 оны байдлаар Монгол улсын экспортын 74.1% нь Хятад руу гарч, импортийн 66.3% Орос болон Хятадаас орж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, 4 тэрбум 119 сая доллартай тэнцэх эргэлттэй байснаас 2 тэрбум 890 сая доллар буюу 70.1%-г зөвхөн 2 хөрштэйгээ хийсэн байна. Эндээс харахад манайх эдийн засгийн хувьд хоёр хөршөөсөө шууд хамаарсан гуравдагч оронтой хийсэн худалдаа маш бага байна. Жишээлбэл, дэлхийн нефть нийлүүлэлтийн зах зээлд 11-рт жагсдаг томоохон орон Казакстантай гэхэд 31 сая долларын буюу энэ нийт эргэлтийн дөнгөж 0.007%-р худалдаа хийсэн баримт байна. Гэтэл манай улсын нийт импортын 27.8%-г нефть ба нефтэн бүтээгдэхүүн эзэлж байх юм.

Ирээдүйд ШХАБ нь чөлөөт худалдааны бүс болох тохиолдолд Монгол орон гишүүн статустай байх юм бол эрхийнхээ дагуу гэрээт улсууд болон эдийн засаг, худалдааны байгууллагуудтай хөнгөлөлттэй үнийн зарчмын дагуу худалдаа хийх бүрэн боломтой болох юм. Энэ утгаараа зөвхөн Төв Азийн орнуудын зах зээлийн үүдийг нээхээс гадна бусад бүсийн байгууллагатай (ASEAN, APEC) хамтран ажиллах боломжтой болох юм.

Эцэст нь манай улс хөрш орнуудынхаа эдийн засгийн ноёрхсон байдлаас ангижрахгүй бол Дэлхийн Худалдааны Байгууллагаас хасагдаж ч болох магадлал байгаа юм.

Jovanovic , Miroslav N (1998): "International Economic Integration" London. Routledge.